



ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛИЙН ЭРДМИЙН ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2023 оны 05 сарын 22 өдөр

Дугаар 02

Улаанбаатар хот

“Хамтын ажиллагаа, нийгмийн түншлэлийн талаар баримтлах бодлого”-ыг батлах тухай

ШУТИС-ийн дүрмийн 4.3, 4.9.1 дэх заалтууд; ШУТИС-ийн Эрдмийн зөвлөлийн дүрмийн 3.2.1, 3.2.6, 5.3, 7.3, 7.5 дахь заалтууд; Эрдмийн зөвлөлийн гишүүдийн Нээлттэй санал хураалтын дүнг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Хамтын ажиллагаа, нийгмийн түншлэлийн талаар баримтлах бодлого”-ыг Эрдмийн зөвлөлийн гишүүдийн саналыг тусган хавсралтын дагуу баталсугай.
2. “Хамтын ажиллагаа, нийгмийн түншлэлийн талаар баримтлах бодлого”-ыг хэрэгжүүлэхтэй холбоотой ажлыг их сургуулийн жил бүрийн ажлын төлөвлөгөө, санхүүгийн төсөвт тусгаж, гүйцэтгэл, үр дүнд хяналт тавьж ажиллахыг их сургуулийн бүтцийн бүх нэгжийн захирлуудад үүрэг болгосугай.
3. “Хамтын ажиллагаа, нийгмийн түншлэлийн талаар баримтлах бодлого”-ыг их сургуулийн профессор, багш, ажилчдад таниулан сурталчилах үйл ажиллагааг зохион байгуулахыг Гадаад харилцаа, нийгмийн түншлэлийн алба, бүрэлдэхүүн сургуулиудад даалгасугай.
4. “Хамтын ажиллагаа, нийгмийн түншлэлийн талаар баримтлах бодлого”-ыг их сургуулийн хэмжээнд 2023 оны 6 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдсүгэй.

ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

ЗӨВЛӨЛИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА




Т.НАМНАН

Д.ЦОЛМОНБААТАР

ШУТИС-ийн Эрдмийн зөвлөлийн 2023 оны
05 дугаар сарын 22 ны өдрийн 02 дугаар
тогтоолын хавсралт



	ХАМТЫН АЖИЛЛАГАА, НИЙГМИЙН ТҮНШЛЭЛИЙН ТАЛААР БАРИМТЛАХ БОДЛОГО ШУТИС-ГХНТА-Б001	Эхний хэвлэлт	2023.05.22
		Өөрчилсөн огноо	-
		Өөрчлөлтийн дугаар	0

ХАМТЫН АЖИЛЛАГАА, НИЙГМИЙН ТҮНШЛЭЛИЙН БОДЛОГО

Боловсруулсан:

ГАДААД, ХАРИЛЦАА, НИЙГМИЙН ТҮНШЛЭЛИЙН АЛБА

Хянасан:

ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН АЛБА

Дэмжсэн:

ШУТИС-ИЙН ЗАХИРЛЫН ЗӨВЛӨЛ, ЭРДМИЙН ЗӨВЛӨЛ

Баталсан:

ШУТИС-ИЙН ЭРДМИЙН ЗӨВЛӨЛ



АГУУЛГА

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ	3
ХОЁР. ХАМРАХ ХҮРЭЭ	3
ГУРАВ. НОРМАТИВ ЭШ ТАТАЛТ	3
ДӨРӨВ. НЭР ТОМЬЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ	3
ТАВ. ХАРИУЦЛАГА, ЭРХ ҮҮРЭГ	4
ЗУРГАА. БОДЛОГО, ЗОРИЛТ	4
ДОЛОО. БОДЛОГЫН ЗАРЧИМ	5
НАЙМ. БОДЛОГЫН ҮНДСЭН ЧИГЛЭЛҮҮД.....	5
ЕС. ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ	9
АРАВ. БУСАД.....	10



НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Энэхүү бодлогын баримт бичгийн үндсэн зорилго нь ШУТИС-ийн хөгжлийг дэмжих гадаад, дотоод хамтын ажиллагааг хөгжүүлэх, их сургуулийн нийгмийн хариуцлага, нийгмийн түншлэлийг нэмэгдүүлэх, аж үйлдвэрийн оролцоог дээшлүүлэхэд баримтлах бодлогыг тодорхойлоход оршино.
- 1.2. Дээд боловсролын өнөөгийн шаардлагад нийцүүлэн нийгэм, аж үйлдвэрийн баримжаатай гадаад, дотоодын түншлэлийн хамтын ажиллагааг хөгжүүлэх хэрэгтэй болжээ.

ХОЁР. ХАМРАХ ХҮРЭЭ

- 2.1. Энэхүү бодлогод ШУТИС-ийн хөгжилд оролцогч гадаад, дотоод сонирхогч талуудын 2030 он хүртэлх хамтын ажиллагаа, нийгмийн түншлэл, аж үйлдвэрийн оролцоо, нийгмийн хариуцлагатай холбоотой бүх харилцаа, санаачилга, үйл ажиллагаа хамаарна.

ГУРАВ. НОРМАТИВ ЭШ ТАТАЛТ

- 3.1. “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого
- 3.2. “Шинэ сэргэлтийн бодлого” дунд хугацааны зорилтот хөтөлбөр
- 3.3. “Боловсролын салбарын хөгжлийн дунд хугацааны төлөвлөгөө 2021-2030”
- 3.4. “ШУТИС-2030 Стратеги төлөвлөгөө”

ДӨРӨВ. НЭР ТОМЬЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ

- 4.1. **Дээд боловсролын олон улсын хамтын ажиллагаа:** Даяаршлын үр нөлөөгөөр бий болсон шинэ бодит байдал, хэрэгцээнд чиглэсэн дээд боловсролын байгууллагын гадаад хамтын ажиллагаа, түншлэлийн бодлого, үйл ажиллагаа.
- 4.2. **Нийгмийн түншлэл:** Төр, бизнес, аж үйлдвэр, төрийн бус байгууллага, иргэний нийгмийн байгууллагуудын хамтын идэвхтэй оролцоотойгоор шийдвэрлэх боломжтой нийгмийн асуудлууд, тэдгээрт нөлөөлж буй хүчин зүйлсийг арилгах зорилготой нэгдсэн, хамтран ажиллах харилцааг хэлнэ.
- 4.3. **Их сургуулийн нийгмийн хариуцлага:** Сургалт, судалгаа, олон нийтийн арга хэмжээ, үйл ажиллагаагаар дамжуулан орон нутаг, улс орны нийгэм, эдийн засгийн сайн сайхан байдалд өөрчлөлт хийх зорилготой нийгмийн хариуцлагын загвар.
- 4.4. **Аж үйлдвэрийн оролцоо:** Үйлдвэрийн санхүүжилттэй хэрэглээний судалгаа, үйлдвэрийн оролцоотой хөтөлбөр боловсруулах механизм, оюутны дадлагын хөтөлбөр, хандив босгох арга хэмжээ гэх мэт хамтрагч талуудад харилцан үр өгөөжтэй их сургууль болон үйлдвэрийн хамтын ажиллагаа, түншлэлийн төсөл, санаачилга.
- 4.5. **Оролцооны манлайлал:** Байгууллагын бодлогын шийдвэр гаргах үйл явц, хэлэлцүүлэгт оролцогч талуудын оролцох боломжийг өргөнөөр бий болгодог манлайллын хэв маяг.



- 4.6. Трансакциональ манлайлал:** Үүрэг даалгавар үр дүнтэй хэрэгжихэд түлхүү анхаарч, шагнал урамшуулал, хариуцлагын аргаар үр дүнтэй гүйцэтгэлийг дэмжин ажилладаг манлайллын хэв маяг.
- 4.7. Өөрчлөлтийн манлайлал:** Хамт олны ажлын байрны сэтгэл ханамж, хүсэл тэмүүллийг нэмэгдүүлэх замаар байгууллагын хамтын гүйцэтгэлийг сайжруулах ёс суртахуун, ёс зүй, үнэт зүйлийн жишиг загварыг удирдлагын зүгээс бий болгож, байгууллагын соёл, хандлагыг өөрчлөх манлайллын хэв маяг.
- 4.8. Хамтын үр нөлөө:** Нийтлэг нэг зорилго, зорилтыг биелүүлэхэд чиглэсэн нийгмийн тодорхой тулгамдсан асуудлыг шийдвэрлэх янз бүрийн салбарын байгууллагуудын хамтын ажиллагаа, нийгмийн түншлэлийн хэлбэр.

ТАВ. ХАРИУЦЛАГА, ЭРХ ҮҮРЭГ

5.1. Гадаад харилцаа, нийгмийн түншлэлийг хариуцсан нэгж

- Энэхүү бодлогыг нийт багш, ажилтанд танилцуулж, түгээн дэлгэрүүлэх ажлыг зохион байгуулна.
- Уг бодлогыг хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөр, төлөвлөгөө болон холбогдох журам зааврыг боловсруулж, хэрэгжүүлнэ.
- Энэхүү бодлогын хэрэгжилтэд жил бүр дүн шинжилгээ хийж, явцын тайланг ШУТИС-ийн Захирлын зөвлөлд танилцуулна.

5.2. Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хариуцсан нэгж

- Энэхүү бодлогын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ.
- Хөндлөнгийн үнэлгээ хийлгэх ажлыг зохион байгуулна.
- Үнэлгээний тайланг ШУТИС-ийн Захирлын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлнэ.

5.3. Бүрэлдэхүүн сургууль, нэгж, нийт багш, судлаач, ажилтнууд

- “Дээд боловсролын гадаад, дотоод хамтын ажиллагаа, нийгмийн түншлэлийн бодлого”-ын зорилго, зорилтуудыг ойлгож, хэрэгжүүлж ажиллана.
- ШУТИС-ийн бүрэлдэхүүн, нэгж бүр хичээлийн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд холбогдох чиг үүргийн дагуу гадаад, дотоод хамтын ажиллагаа, нийгмийн түншлэлийн зорилтуудыг тусгаж, хэрэгжүүлж ажиллана.

ЗУРГАА. БОДЛОГО, ЗОРИЛТ

6.1. Бодлогын тодорхойлолт

Сонирхогч талуудын хэрэгцээнд нийцүүлэн оролцооны буюу ардчилсан манлайлал, нээлттэй засаглал, чанартай үйлчилгээ, аж үйлдвэрийн оролцоо, нийгмийн хариуцлагын зарчим дээр түшиглэн харилцан үр өгөөжтэй гадаад, дотоод хамтын ажиллагаа, их сургуулийн нийгмийн түншлэл, аж үйлдвэрийн оролцоог дэмжих хамтын үр нөлөөний түншлэлийг хөгжүүлнэ.

6.2. Тэргүүлэх зорилтууд

- 6.2.1. ШУТИС-ийн хөгжлийн зорилтуудыг дэмжсэн төр, гадаад, дотоодын санхүүжүүлэгч байгууллагууд, инновацийн хөрөнгө оруулагчдын оролцооны



манлайлал дээр суурилсан хамтын үр нөлөөний түншлэлийн загварыг хөгжүүлж, 2025 он гэхэд байгууллагын үйл ажиллагаанд нэвтрүүлэх;

- 6.2.2. “Аж үйлдвэрийн хөгжлийг дэмжигч ШУТИС” санаачилгыг эхлүүлэн инженерийн боловсролын чанар, үнэ цэн, нийгмийн баримжаатай бизнесийг хөгжүүлэх, аж үйлдвэрийн оролцооны жишиг загварыг бий болгож, 2026 он гэхэд байгууллагын үйл ажиллагаанд нэвтрүүлэх;
- 6.2.3. Боловсрол, судалгааны, нийгмийн инновацийн төлөө нэгдмэл сонирхолтой талууд хамтран ажиллах нээлттэй, чөлөөт, цахим экосистемийг 2027 он гэхэд бий болгож, оролцогч талуудын сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх;
- 6.2.4. Нийгэм, аж үйлдвэрт үнэ цэнтэй олон улсын төсөл, хөтөлбөр төлөвлөх, хэрэгжүүлэх салбар, тэнхим, профессор багш нарын ур чадварыг сайжруулахад чиглэсэн сургалтын тоо хэмжээ, хүртээмжийг нэмэгдүүлэх ажлыг 2030 он хүртэл тасралтгүй хийх;
- 6.2.5. “Дэлхийн ШУТИС” санаачилгыг 2024 онд эхлүүлж, гадаадад суралцах, мэргэжил дээшлүүлэх, гадаадын зөвлөх, зочин профессоруудыг урих, гадаад оюутнуудыг элсүүлэх хөтөлбөрүүдийн тоо хэмжээ, хүртээмжийг нэмэгдүүлэх;
- 6.2.6. Гадаад оюутан шинэ соёл, ахуй амьдрал, сургалтын орчинд дасан зохицоход нь туслах үйлчилгээ, соёлын хөтөлбөрийн тоо, хэмжээг нэмэгдүүлэх ажлыг тасралтгүй 2030 он хүртэл хийх;
- 6.2.7. “Хот, хөдөөгийн хөгжлийг дэмжигч ШУТИС” санаачилгыг 2024 оноос эхлүүлэн орон нутгийн хүний хөгжил, нийгмийн хөгжил, эдийн засгийн тогтвортой өсөлтийг дэмжсэн хамтын ажиллагааны төсөл, хөтөлбөрийн тоо, хэмжээг нэмэгдүүлнэ.

ДОЛОО. БОДЛОГЫН ЗАРЧИМ

- 7.1. **Хэрэглэгч төвтэй хамтын ажиллагаа:** Гадаад, дотоод оролцогч талын сонирхол, зорилт, хэрэгцээг тэргүүнд тавьсан хамтын ажиллагааг дэмжин ажиллана.
- 7.2. **Оролцооны манлайлалд тулгуурласан хамтын ажиллагаа:** Хамтын ажиллагаанд бүх хүн, оролцогч тал хамтрах боломжийг бүрдүүлэх ардчилсан зарчмыг баримтлан ажиллана.
- 7.3. **ШУТИС төвтэй түншлэл:** Гадаад, дотоод хамтын ажиллагааг хөгжүүлэхэд үр өгөөж, үр дүн нь ШУТИС-ийн хөгжлийг дэмжсэн байна.
- 7.4. **Шийдэлд чиглэсэн харилцаа:** Үр дүнтэй, үр ашигтай хамтын ажиллагааг хөгжүүлэхэд учирч буй саад бэрхшээлийг арилгах шийдлийг эрэлхийлсэн харилцааг дэмжин ажиллана.
- 7.5. **Дотоод хүсэл тэмүүлэлд тулгуурласан хамтын үр нөлөө:** Боловсролын өндөр чанартай, үнэ цэнтэй, нийгмийн баримжаатай бизнесийг дэмжих хүсэл тэмүүлэл, дотоод сэдлийг урамшуулна.

НАЙМ. БОДЛОГЫН ҮНДСЭН ЧИГЛЭЛҮҮД

- 8.1. **Бодлогын 6.2.1-т заасан оролцооны манлайлал дээр суурилсан нийгмийн өөрчлөлтийн төлөө хамтын үр нөлөөний түншлэлийн загварыг нэвтрүүлэх зорилтын хүрээнд:**



- 8.1.1. Нийгэм, аж үйлдвэрийн асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн дээд боловсролын байгууллагын үүрэг, үр нөлөөг дээшлүүлэхэд чиглэсэн их сургууль, төр, иргэний нийгэм, хувийн хэвшил, аж үйлдвэрийн байгууллагуудын оролцоог нэгтгэсэн хамтын үр нөлөөний механизмыг ШУТИС-д нутагшуулна.
- 8.1.2. Хамтын ажиллагаа, нийгмийн түншлэлийн шилдэг туршлагыг түгээн дэлгэрүүлэх, урамшуулах тайлангийн танилцуулах өдөрлөгийг жил бүр тогтмол зохион байгуулна.
- 8.1.3. Бүрэлдэхүүн сургууль, хүрээлэн, салбар, тэнхимийн хамтын ажиллагаа, нийгмийн түншлэлийг хөгжүүлэх чадамжийг сайжруулахад дэмжлэг үзүүлэх оролцооны болон трансакциональ манлайлал дээр тулгуурласан хамтын ажиллагаа, нийгмийн түншлэл эхлүүлэх, төлөвлөх, хэрэгжүүлэх механизмыг нэвтрүүлэх жишиг загвар, аргачлал боловсруулж, түгээн дэлгэрүүлнэ.

8.2. Бодлогын 6.2.2-т заасан “Аж үйлдвэрийн хөгжлийг дэмжигч ШУТИС” санаачилгыг эхлүүлэн инженерийн боловсролын чанар, үнэ цэн, нийгмийн баримжаатай бизнесийг хөгжүүлэх аж үйлдвэрийн оролцооны жишиг загварыг бий болгож, нэвтрүүлэх зорилтын хүрээнд:

- 8.2.1. Аж үйлдвэрийн хэрэгцээнд тулгуурлан мэргэжлийн хөтөлбөрийг сайжруулах зорилготой боловсролын түншлэлийг дэмжих зорилгоор аж үйлдвэрийн оролцогч талуудыг ШУТИС-ийн сургалтын бодлого, чанарын асуудал эрхэлсэн нэгжүүдтэй холбох, хоёр талт хөтөлбөрийн түншлэлийн хамтын ажиллагааг хөгжүүлэх загварыг бий болгож, нэвтрүүлнэ.
- 8.2.2. ШУТИС-ийн багш, оюутан аж үйлдвэрийн шинэ мэдлэг, ур чадвар, технологи, хандлага, менежментээс суралцах боломж олгох өөрчлөлтийн манлайлалд тулгуурласан аж үйлдвэрийн дадлага, зөвлөх профессор, аутсорсинг, оффшорингийн гадаад, дотоод хамтын ажиллагааны жишиг загварыг бий болгож, нэвтрүүлнэ.
- 8.2.3. Аж үйлдвэрт хувь нэмэр оруулах гоц авьяастныг бэлтгэх зэргийн болон зэргийн бус хөдөлгөөнт (мобилити), шилжин суралцах олон улсын боловсролын хөтөлбөрүүдийг эхлүүлэх олон талт хамтын ажиллагааны жишиг загваруудыг бий болгож, нэвтрүүлнэ.
- 8.2.4. Багшийн мэргэжлийн мэдлэг, ур чадвар, хандлагыг дээшлүүлэх зорилгоор аж үйлдвэрийн байгууллагуудтай байгуулах гэрээ, хамтын ажиллагааны төлөвлөгөөнд багшийн үйлдвэрлэлийн дадлагын хөтөлбөрийг тусгах, тогтмол хэрэгжүүлдэг шилдэг хөтөлбөрүүдтэй болно.

8.3. Бодлогын 6.2.3-т заасан хамтын ажиллагааны нээлттэй, чөлөөт, цахим экосистемийг бий болгож, оролцогч талуудын сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд:

- 8.3.1 ШУТИС-ийн англи хэл дээрх цахим хуудасны хүртээмж, агуулга, мэдээллийн чанарыг сайжруулах зорилгоор хэрэглэгч төвтэй бүтэц бүхий цахим хуудасны жишиг загварыг бий болгож, хэрэглээнд нэвтрүүлнэ.
- 8.3.2 Хамтын ажиллагааны төсөл, хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжүүлэх мэргэжлийн үйлчилгээг шуурхай, эмх цэгцтэй болгох зорилгоор гадаад, дотоод



түншлэлийн үйл ажиллагааг цахимжуулах төслийг олон улсын эсвэл дотоодын санхүүжүүлэгч байгууллагын санхүүжилтээр хэрэгжүүлнэ.


- 8.3.3 Олон улсын дээд боловсролын хамтын ажиллагаа, аж үйлдвэрийн оролцоо, нийгмийн хариуцлагын хүрээнд хэрэгжүүлсэн үйл ажиллагааны үр дүн, үр өгөөж, үр нөлөөний статистик үзүүлэлтийг хязгаарлагдмал болон нээлттэй гэж хоёр ангилж оролцогч талуудад тогтмол мэдээлэх цахим мэдээллийн сантай болно.

8.4. Бодлогын 6.2.4-т заасан нийгэм, аж үйлдвэрт үнэ цэнтэй олон улсын төсөл, хөтөлбөр төлөвлөх, хэрэгжүүлэх салбар, тэнхим, профессор багш нарын үр чадварыг сайжруулахад чиглэсэн сургалтын тоо хэмжээ, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд:

- 8.4.1. Гадаад, дотоод хамтын ажиллагаа, түншлэлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрийн үнэлгээнд тогтвортой хөгжил, нийгмийн хариуцлага, сайн засаглалын шалгуур үзүүлэлтүүдийг заавал тусгадаг олон улсын жишигт нийцсэн аргачлалыг боловсруулж, нэвтрүүлнэ.
- 8.4.2. Гадаад, дотоодын байгууллагуудын санхүүжилт, хөрөнгө оруулалтыг татах нийгмийн баримжаатай бизнес, үйлдвэрлэлийн төслийн санал боловсруулах жишиг загварыг бий болгож, санхүүжүүлэгч байгууллагуудтай холбон зуучилдаг хөтөлбөртэй болно.
- 8.4.3. Олон улсын төсөл, хөтөлбөрийг аюулгүй, үр дүнтэй, үр өгөөжтэй хэрэгжүүлэх мэдлэг, үр чадвар хандлагыг төлөвшүүлэх модуль сургалтын хөтөлбөр боловсруулж, тогтмолжуулна.

8.5. Бодлогын 6.2.5-т заасан “Дэлхийн ШУТИС” санаачилгыг эхлүүлж, гадаадад суралцах, мэргэжил дээшлүүлэх, гадаадын зөвлөх, зочин профессоруудыг урих, гадаад оюутнуудыг элсүүлэх хөтөлбөрүүдийн тоо хэмжээ, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд:

- 8.5.1. Дэлхийн шилдэг их сургууль, судалгааны байгууллагуудад ШУТИС-ийн багш, судлаач, ажилтан, оюутнуудыг богино хугацаагаар томилолтоор ажиллаж, судалгаа хийх боломжийг олгодог хөдөлгөөнт хөтөлбөрүүд (mobility)-ийг бий болгож, тогтмолжуулна.
- 8.5.2. Суралцагчдын иргэний боловсрол, хувь хүний хөгжил, нийтийн эрүүл мэндийн боловсролыг дэмжих зорилгоор гадаад улс оронд сайн дурын арга хэмжээ, мэргэжлийн дадлагыг богино хугацаанд хийдэг олон улсын хөтөлбөрүүдийг хэрэгжүүлнэ.
- 8.5.3. Оюутнуудад гадаадын шилдэг аж үйлдвэрийн байгууллагуудад мэргэжлийн дадлага хийж, орчин үеийн үйлдвэрлэлийн технологи, менежментээс суралцах боломжийг олгодог олон улсын хөтөлбөрүүдийг боловсруулж, хэрэгжүүлнэ.
- 8.5.4. Гадаадын шилдэг аж үйлдвэрийн байгууллагуудад багш богино хугацаагаар мэргэжлээрээ ажиллаж, мэдлэг, үр чадвар, хандлагаа сайжруулдаг багшийн олон улсын аж үйлдвэрийн дадлагын хөтөлбөрүүдийг бий болгож, хэрэгжүүлнэ.



- 8.5.5. ШУТИС-ийн нийгмийн хариуцлагын хүрээнд хилийн чанад дахь Монголчуудын хүний хөгжлийг дэмжсэн цахим болон танхим хосолсон насан туршийн болон зэргийн хөтөлбөрүүдийг нэмэгдүүлэх олон улсын боловсролын нийгмийн түншлэлийн загвар төсөл, хөтөлбөрүүдийг бий болгож, хэрэгжүүлнэ.
- 8.5.6. “Дэлхийн ШУТИС” санаачилгын хүрээнд гадаадын боловсролын байгууллагуудтай олон улсын боловсролын түншлэлийн гэрээ байгуулан, гадаад оюутан элсүүлэх төсөл хөтөлбөрүүдийг бий болгож, хэрэгжүүлнэ.

8.6. Бодлогын 6.2.6-д заасан гадаад оюутан шинэ соёл, ахуй амьдрал, сургалтын орчинд дасан зохицоход нь туслах үйлчилгээ, соёлын хөтөлбөрийн тоо, хэмжээг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд:

- 8.6.1. Гадаад оюутанд Монголын соёл, ахуй, сургалтын орчинд дасан зохицоход туслах, чиглүүлэх уулзалтуудыг бий болгож, тогтмолжуулна.
- 8.6.2. Гадаад оюутанд зориулсан Монголын түүх, соёлын мэдлэгийг түгээн дэлгэрүүлэх хөтөлбөрүүдийг бий болгож, тогтмолжуулна.
- 8.6.3. Гадаад, дотоод оюутны нөхөрлөлийг дэмжих, гадаад оюутны монгол хэлний ур чадварыг дэмжих зорилгоор “Монгол найз” хөтөлбөрийг бий болгож, нэвтрүүлнэ.

8.7. Бодлогын 6.2.7-д заасан хот, хөдөөгийн хүний хөгжил, нийгмийн хөгжил, эдийн засгийн тогтвортой өсөлтийг дэмжсэн хамтын ажиллагааны төсөл, хөтөлбөрийн тоо, хэмжээг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд:

- 8.7.1. Орон нутгийн хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээтэй уялдуулан ур чадвартай хүний нөөцийн нийлүүлэлтийг тогтвортой нэмэгдүүлэх зорилгоор ШУТИС-ийн бакалаврын түвшний болон мэргэжлийн боловсролын хөтөлбөрүүдийг орон нутагт дамжуулах франчайз хэлбэрийн нийгмийн баримжаатай боловсролын түншлэлийн жишиг загварыг боловсруулж, түгээн дэлгэрүүлнэ.
- 8.7.2. Хот, хөдөөгийн нийгэм, соёлын хөгжлийг дэмжих, хүрээлэн буй орчны асуудлуудыг шийдвэрлэх зорилготой нийгмийн өөрчлөлтийг дэмжсэн хамтын үр нөлөөний жишиг төсөл хөтөлбөрүүдийг бий болгож, үндэсний хэмжээнд түгээн дэлгэрүүлнэ.
- 8.7.3. Орон нутгийн эдийн засгийн тогтвортой өсөлтийг дэмжих зорилготой ШУТИС болон орон нутгийн хамтын ажиллагааг дэмжих хурдасгуур хөтөлбөрүүдийг орон нутгийн иргэд, байгууллагуудтай хамтран хэрэгжүүлж, үр дүн, үр өгөөжийг нь нэмэгдүүлнэ.
- 8.7.4. Орон нутгийн хүний капиталыг сайжруулах зорилгоор орон нутгийн залуу манлайлагчдыг ШУТИС-д суралцуулах боломжийг нэмэгдүүлэх жишиг төсөл, хөтөлбөрийн бий болгож, харилцан үр ашигтай байдлаар хөгжүүлнэ.



ЕС. ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

9.1 Дээд боловсролын олон улсын хамтын ажиллагаа, нийгмийн түншлэлийн бодлогыг 2023-2030 он хүртэл 7 жилийн хугацаанд дараах үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

- Нэгдүгээр үе шат (2023-2025 он);
- Хоёрдугаар үе шат (2026-2028 он);
- Гуравдугаар үе шат (2029-2030 он);

9.2 Бодлогын хэрэгжилтийн үр дүнг дараах шалгуур үзүүлэлтээр хэмжинэ.

№	Шалгуур үзүүлэлт	Холбогдох чиглэл	Суурь түвшин 2022	Хүрэх үр дүн		
				I-үе шат	II-үе шат	III-үе шат
				2023-2025 он	2026-2028 он	2029-2030 он
1.	Нийгмийн хариуцлага, тогтвортой хөгжлийг дэмжсэн "хамтын үр нөлөө"-ний загвараар хэрэгжсэн төсөл, хөтөлбөрийн тоо	8.1	0	3	5	7
2.	Аж үйлдвэрийн хамтын ажиллагааны их сургуулийн бэлэн байдлын индекс	8.2	2	4	5	7
3.	Гадаад харилцаа, нийгмийн түншлэлийн удирдлагын цахим шилжилтийн индекс	8.3	1	3	5	7
4.	Эрасмус төслийн тоо	8.4	11	13	15	18
5.	Хөгжлийн албан ёсны туслалцааны төсөл (ODA)	8.4	3	5	7	9
6.	Гадаад багш, ажилтны эзлэх хувь	8.5	1.1%	2.5%	5%	8%
7.	Солилцооны хөтөлбөрөөр гадаадад явсан оюутны тоо	8.5	80	110	140	180
8.	Солилцооны хөтөлбөрөөр гадаадад явсан багш, ажилтны тоо	8.5	100	150	175	200
9.	Солилцооны хөтөлбөрөөр гадаадаас ирсэн оюутны тоо	8.5	15	50	100	150
10.	Гадаад оюутны эзлэх хувь	8.6	0.34%	2.5%	4.5%	6.5%
11.	Хөтөлбөр дамжуулах түншлэлд хамрагдсан орон нутгийн тоо	8.7	3	5	8	11
12.	Орон нутгийн эдийн засгийн хөгжлийг дэмжих "хамтын үр нөлөө"-ний загвараар хэрэгжсэн төсөл, хөтөлбөрийн тоо	8.7	0	10	20	30
13.	Орон нутгийн хүний нөөцийг дэмжих төсөл хөтөлбөрийн тоо	8.7	0	3	6	8



АРАВ. БУСАД

- 10.1 Бодлогод нэмэлт өөрчлөлт оруулах саналыг ШУТИС-ийн Эрдмийн зөвлөлөөр хэлэлцүүлэн, шийдвэрлүүлнэ.
- 10.2 Бодлогод үл нийцсэн үйл ажиллагаа явуулсан нэгж, хувь хүнд Монгол Улсын хууль тогтоомж, холбогдох дүрэм журмын дагуу хариуцлага хүлээлгэнэ.
- 10.3 Гадаад харилцаа, нийгмийн түншлэлийн асуудал эрхэлсэн нэгж хичээлийн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд гадаад, дотоод хамтын ажиллагаа, нийгмийн түншлэлийн зорилтуудыг тусгаж, хэрэгжүүлнэ.